



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2013 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 0/305

Дорноговь аймаг, Сайншанд сум

Салбар зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /г/, /е/, 29.1.3 /н/, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Засгийн газрын 2007 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг” хавсралтын 10.1 дэх заалт, 2012 оны 222 дугаар тогтоолын 11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх аймгийн салбар зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

- |               |                                                               |
|---------------|---------------------------------------------------------------|
| Дарга:        | - Аймгийн Засаг даргын орлогч                                 |
| Нарийн бичиг: | - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга                       |
| Гишүүд:       | - ХБХ-ийн Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын мэргэжилтэн |
|               | - Аймгийн Аудитын газрын дарга                                |
|               | - Аймгийн Татварын хэлтсийн дарга                             |
|               | - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга                    |
|               | - Аймгийн Байгаль орчны газрын дарга                          |
|               | - “Доншен газрын тос /Монгол/” ХХК-ийн төлөөлөл               |
|               | - “Арева” группын төлөөлөл                                    |
|               | - “Монголын алт МАК” ХХК-ийн төлөөлөл                         |

- “Монголрос цветмет” нэгдлийн төлөөлөл

- “Байгаль орчны иргэний зөвлөл”-ийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөл ТББ-ийн тэргүүн

- Байгаль орчныг хамгаалах зөвлөл ТББ-ын тэргүүн

2. Аймгийн нутаг дэвсгэр дээр ашигт малтмал, газрын тос, цөмийн энергийн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компани болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутагт төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, мөн холбогдох гэрээний дагуу авсан төлбөр зэрэг орлогын жилийн тайланг дараа оны 4-р сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байхыг салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 239 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П. ГАНХУЯГ